



ҮНДЭСНИЙ
СТАТИСТИКИЙН
ХОРОО

МОНГОЛ УЛСЫН ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН СТАТИСТИК




Улаанбаатар хот
2026 он

МОНГОЛ УЛСЫН ХҮҮХЭД ХАМГААЛЛЫН СТАТИСТИК ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН ТАНИЛЦУУЛГА

1. Насанд хүрээгүй охидын жирэмслэлт: 2025 онд 10-19 насны нийт 2868 охид жирэмсэлсэн нь өмнөх оноос 407 (16.5%)-гоор нэмэгдсэн байна.


ЗУРАГ 1. ӨСВӨР НАСНЫ ОХИДЫН ЖИРЭМСЛЭЛТ



Эх үүсвэр: Эрүүл мэндийн яам

2. Охидын төрөлт: 2025 оны байдлаар 1000 хүнд ногдох өсвөр насны охидын төрөлтийн түвшин 14.7 байгаа нь өмнөх оноос 1 нэгжээр буурсан байна.


ЗУРАГ 2. 1 000 ХҮНД НОГДОХ ӨСВӨР НАСНЫ ОХИДЫН ТӨРӨЛТИЙН ТҮВШИН



Эх үүсвэр: Эрүүл мэндийн яам

3. Охидын үр хөндөлт: 2025 оны байдлаар 1000 хүнд ногдох өсвөр насны охидын үр хөндөлтийн түвшин 4 байгаа нь өмнөх онтой ижил түвшинд байна.


ЗУРАГ 3. 1 000 ХҮНД НОГДОХ ӨСВӨР НАСНЫ ОХИДЫН ҮР ХӨНДӨЛТИЙН ТҮВШИН



Эх үүсвэр: Эрүүл мэндийн яам

4. **Насанд хүрээгүй бэлгийн хүчирхийллийн хохирогч:** 2025 онд 18 хүртэлх насны нийт 396 хүүхэд хүчиндэх гэмт хэргийн хохирогч болсон нь өмнөх оноос 40 (9.2%) тохиолдлоор буурсан байна.


ЗУРАГ 4. БЭЛГИЙН ХҮЧИРХИЙЛЛИЙН ХОХИРОГЧ ХҮҮХДИЙН ТОО



Эх үүсвэр: Цагдаагийн ерөнхий газар

5. **Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч:** Цагдаагийн ерөнхий газарт бүртгэгдсэн гэмт хэргийн мэдээгээр 2025 онд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч 6 хүүхэд байгаа нь өмнөх оноос 4 тохиолдлоор буурчээ.

ЗУРАГ 5. ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН ХОХИРОГЧ ХҮҮХЭД



Эх үүсвэр: Цагдаагийн ерөнхий газар

6. **Амиа хорлолт:** Эрүүл мэндийн яамны 2025 оны мэдээллээр нийт 45 хүүхэд амиа хорлосон нь өмнөх оноос 17 тохиолдлоор буурсан байна. Насны бүлгээр авч үзвэл 5-9 насны 1, 10-14 насны 11, 15-19 насны 33 хүүхэд 2025 онд амиа хорлосон байна.


ХҮСНЭГТ 1. АМИА ХОРЛОСОН ХҮҮХДИЙН ТОО

Насны бүлэг	2021	2022	2023	2024	2025
5-9 нас	3	3	1	1	1
10-14 нас	18	14	11	24	11
15-19 нас	41	37	34	37	33
Нийт	62	54	46	62	45

Эх үүсвэр: Эрүүл мэндийн яам

7. **Амиа хорлох эрсдэл бүхий хүүхэд:** Нийгмийн үзүүлэлтийн 2023 оны түүвэр судалгааны үр дүнгээр 15-19 насны хүүхэд, залуусын 4.1 хувь, 20-24 насны залуусын 1.9 хувь нь амиа хорлох талаар бодсон гэсэн үр дүн гарсан байна. Энэ үзүүлэлт нь 2023 оны судалгаанд шинээр нэмэгдсэн сэтгэцийн эрүүл мэнд бүлгийн үр дүн юм.
8. **Гэмт хэргийн улмаас нас барсан:** Цагдаагийн ерөнхий газарт бүртгэгдсэн гэмт хэргийн мэдээгээр сүүлийн жилүүдэд гэмт хэргийн улмаас нас барсан хүүхдийн тоо нэмэгдсээр байна. 2025 оны байдлаар гэмт хэргийн улмаас 119 хүүхэд нас барсан нь өмнөх оноос 8-аар нэмэгдсэн байна.


ЗУРАГ 6. ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС НАС БАРСАН ХҮҮХДИЙН ТОО



Эх үүсвэр: Цагдаагийн ерөнхий газар

9. **Гэмт хэргийн улмаас гэмтсэн хүүхэд:** 2025 онд гэмт хэргийн улмаас 935 хүүхэд гэмтсэн нь өмнөх оноос 62-оор буурсан байна.


ЗУРАГ 7. ГЭМТ ХЭРГИЙН УЛМААС ГЭМТСЭН ХҮҮХЭД



Эх үүсвэр: Цагдаагийн ерөнхий газар

10. Эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн хүүхэд: 2025 онд 1-19 насны нийт 209931 хүүхэд эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн нь өмнөх оноос 16.8 (7.4%) мянгаар буурсан байна. Эмнэлэгт хэвтсэн хүүхдийн 84.8 хувь нь 1-14 насных байна.

ЗУРАГ 8. ЭМНЭЛЭГТ ХЭВТЭЖ ЭМЧЛҮҮЛСЭН ХҮҮХЭД



Эх үүсвэр: Эрүүл мэндийн яам

15. Хүүхдүүдийн зонхилох өвчлөл: 2025 оны байдлаар 10000 хүнд ногдох хүүхдийн зонхилон тохиолдох өвчлөлийг амьсгалын замын өвчин тэргүүлж байна. Амьсгалын замын тогтолцооны өвчлөл 2025 онд 3038 болж, өмнөх оноос 20-иор нэмэгдсэн байна.


ЗУРАГ 9. 10 000 ХҮҮХДЭД НОГДОХ ХҮҮХДИЙН ЗОНХИЛОХ ӨВЧЛӨЛ



Эх үүсвэр: Эрүүл мэндийн яам

16. Шүдний цоорол өвчтэй хүүхэд: Эрүүл мэндийн яамны мэдээллээр 2025 онд 121.4 мянган хүүхэд шүдний цоорол өвчтэй байгаа нь өмнөх оноос 27.1 (28.8%) мянган хүүхдээр нэмэгдсэн байна.


ЗУРАГ 10. ШҮДНИЙ ЦООРОЛ ӨВЧТЭЙ ХҮҮХЭД



Эх үүсвэр: Эрүүл мэндийн яам

17. **Төрөх явцдаа саажилттай болсон хүүхэд:** Эрүүл мэндийн яамны өвчлөлийн мэдээллээр 2025 онд төрөлхийн саажилттай 0-17 насны нийт 2.5 мянган тохиолдол бүртгэгдсэн байгаа нь өмнөх оноос 281 (10.3%) хүүхдээр буурсан байна.


ЗУРАГ 11. СААЖИЛТТАЙ ТӨРСӨН ХҮҮХЭД



Эх үүсвэр: Эрүүл мэндийн яам

18. **Хавдартай хүүхэд:** 2025 онд 126 хүүхэд шинээр хавдраар өвчилсөн байгаа нь өмнөх оноос 22 (14.9%) аар буурсан байна.


ЗУРАГ 12. ХАВДАРТАЙ ХҮҮХДИЙН ТОО



Эх үүсвэр: Эрүүл мэндийн яам

19. **Дархлаажуулалтад хамрагдсан хүүхэд /төрлөөр/:** Нэг хүртэлх насны хүүхдийн 99.6 хувь нь сүрьеэгийн вакцинд, 95.4 хувь нь халдварт саагийн вакцинд, 96.1 хувь нь Сахуу, хөхүүл ханиад, татран + гепатит В + хемофилюс инфлюенз В өвчний эсрэг 5-т вакцинд, 95.6 хувь нь Улаан бурхан+ гахайн хавдар+улаанууд вакцинд, 98.6 хувь нь В гепатит вакцинд, 96.1 хувь нь Пневмококкийн эсрэг вакцинд хамрагдсан байна.

ЗУРАГ 13. ДАРХЛААЖУУЛАЛТАД ХАМРАГДСАН ХҮҮХДИЙН ХУВЬ




¹Сүрьеэгийн вакцин

² Сахуу, хөхүүл ханиад, татран + Хепатит В + Хемофилюс инфлюенз В өвчний эсрэг 5-т вакцин

Эх үүсвэр: Эрүүл мэндийн яам

20. **Шинэ төрсөн хүүхэд:** 2025 онд нийт 55.5 мянган эх амаржиж, 56.2 мянган хүүхэд мэндэлсэн байна. Төрсөн хүүхдийн тоо өмнөх оноос 3.4 (5.7%) мянгаар буурсан байна.


ЗУРАГ 14. ТӨРСӨН ХҮҮХДИЙН ТОО



Эх үүсвэр: Улсын бүртгэлийн ерөнхий газар

21. **Эх хүүхдийн эндэгдэл:** 2025 оны байдлаар 100 000 амьд төрөлтөд ногдох эхийн эндэгдлийн түвшин 31 болж, өмнөх оноос 9-өөр нэмэгдсэн байна.


ЗУРАГ 15. ЭХИЙН ЭНДЭГДЛИЙН ТҮВШИН, 100 000 АМЬД ТӨРӨЛТӨД НОГДОХ



Эх үүсвэр: Эрүүл мэндийн яам

2025 онд 1000 амьд төрөлтөд ногдох тав хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн түвшин 17 болж өмнөх оноос 2-оор нэмэгдсэн байна.


ЗУРАГ 16. ТАВ ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХДИЙН ЭНДЭГДЛИЙН ТҮВШИН, 1000 амьд төрөлтөд ногдох



Эх үүсвэр: Эрүүл мэндийн яам

22. **Хүүхдийн таргалалт:** Нийгмийн үзүүлэлтийн 2023 оны түүвэр судалгааны үр дүнгээр 5 хүртэлх насны хүүхдийн 12.8 хувь нь дунд болон хүнд хэлбэрийн илүүдэл жинтэй байгаа нь өмнөх судалгаанаас 2.3 нэгж хувиар, хүнд хэлбэрийн илүүдэл жинтэй хүүхдийн хувь 3.4 болж, 0.5 нэгж хувиар тус тус нэмэгджээ.


ЗУРАГ 17. ИЛҮҮДЭЛ ЖИНТЭЙ 5 ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХЭД



Эх үүсвэр: УСХ, Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа, 2023

23. **Бэлгийн замын халдварт өвчтэй хүүхэд:** 2025 оны байдлаар бэлгийн замын халдварт өвчтэй 878 хүүхэд байгаа нь өмнөх оноос 92-оор, 2021 оноос 449-оор тус тус нэмэгдсэн байна.

ЗУРАГ 18. БЭЛГИЙН ЗАМЫН ХАЛДВАРТ ӨВЧТЭЙ ХҮҮХЭД



Эх үүсвэр: Эрүүл мэндийн яам

24. **Төрөлхийн тэмбүү:** 2025 оны байдлаар төрөлхийн тэмбүүтэй 25 хүүхэд байгаа нь өмнөх оноос 12 тохиолдлоор нэмэгдсэн байна. (Хүснэгт 2.)
25. **Тэмбүүтэй хүүхэд:** 2025 оны байдлаар нийт тэмбүүтэй хүүхэд 648 болж, өмнөх оноос 11-ээр нэмэгдсэн байна.


ХҮСНЭГТ 2. ТЭМБҮҮТЭЙ ХҮҮХЭД

	2021	2022	2023	2024	2025
Төрөлхийн тэмбүү /1 хүртэлх насны/	19	20	31	13	25
Нийт тэмбүүтэй хүүхэд	369	506	550	637	648

Эх үүсвэр: Эрүүл мэндийн яам

26. **Оюун ухааны хомсдолтой хүүхэд:** Нийгмийн зарим үзүүлэлт мэдээгээр хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн мэдээллийг цуглуулж олон нийтэд тархаадаг бөгөөд 2013 оноос оюун ухааны хомсдолтой иргэдийн мэдээллийг олон нийтэд тархаахаа больсон. 2025 онд сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй 3185 хүүхэд байгаа нь өмнөх оноос 535 (20.2%) хүүхдээр өссөн байна.

ЗУРАГ 19. СЭТГЭЦИЙН ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХЭД*




Тайлбар: * 2013 оноос маягт өөрчлөгдөж оюун ухааны хомсдолтой гэдгийг сэтгэцийн хөгжлийн бэрхшээлтэй гэж өөрчилсөн.

Эх үүсвэр: ҮСХ, Нийгмийн зарим үзүүлэлтийн мэдээ

27. **Сэтгэл зүйн тулгамдсан асуудалтай хүүхэд:** 0-18 насны хүүхдийн сэтгэл гутралын тусгайлсан судалгаа одоогоор хийгдээгүй. Харин ҮСХ-ноос 2023 онд зохион байгуулсан Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаагаар сэтгэл гутрах болон түгших шинж тэмдэг сүүлийн 2 долоо хоногийн хугацаанд 15-24 насны залуучуудын 6.4%-д нь илэрсэн байна.

28. Тээврийн хэрэгсэл жолооддог хүүхэд: Засгийн газрын 2018 оны 239 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын замын хөдөлгөөний дүрмийн дагуу тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 18 наснаас эхлэн олгож байна. 2025 онд тээврийн хэрэгсэл жолоодох насанд хүрээгүй хүүхэд замын хөдөлгөөнд оролцсон 1715 тохиолдол бүртгэгдсэн байна.

ЗУРАГ 20. ЖОЛООДОХ ЭРХИЙН ЗӨРЧИЛ ГАРГАСАН 18 ХҮРТЭЛ НАСНЫ ХҮҮХДИЙН ТОО



Эх үүсвэр: Цагдаагийн ерөнхий газар

29. Сэтгэцийн өвчтэй хүүхэд: Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвд 2025 онд 318 хүүхэд хэвтэн эмчлүүлсэн байна. Харин Эрүүл мэндийн хөгжлийн төв (ЭМХТ)-ийн мэдээллээр 2025 онд 0-14 насны сэтгэцийн өвчлөлтэй 7638 хүүхэд бүртгэгдсэн байна.


ХҮСНЭГТ 3. СЭМҮТ-Д ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛСЭН БОЛОН ЭМХТ-Д БҮРТГЭГДСЭН ХҮҮХДИЙН ТОО

	2021	2022	2023	2024	2025
СЭМҮТ-д хэвтэн эмчлүүлсэн хүүхдийн тоо /0-17/	68	285	314	390	318
Хүүхдийн сэтгэцийн өвчлөл /0-14 нас/	4 719	7 535	5 107	5 570	7 638

Эх үүсвэр: Эрүүл мэндийн яам

30. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд / төрөл, ангилал/: Монгол Улсад 0-17 насны 13,161 хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд байгаагийн 61.1 хувь нь эрэгтэй, 38.9 хувь нь эмэгтэй хүүхэд байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоо өмнөх оноос 785 (6.3%)-аар өссөн байна.

ЗУРАГ 21. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХЭД, ХҮЙСЭЭР



Эх үүсвэр: ҮСХ, Нийгмийн зарим үзүүлэлийн мэдээ

ХҮСНЭГТ 4. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХЭД, ХЭЛБЭРЭЭР

Хөгжлийн бэрхшээлийн хэлбэр	2021	2022	2023	2024	2025
Бүгд	11 108	11 818	12 040	12 376	13 161
Харааны	1 013	1 023	883	787	828
Ярианы	772	846	521	654	707
Сонголын	584	580	671	517	538
Хөдөлгөөний	2 295	2 323	2 131	2 053	2 045
Сэтгэц	2 085	2 380	2 469	2 650	3 185
Хавсарсан	1 080	1 064	1 106	1 183	1 285
Бусад	3 279	3 602	4 259	4 532	4 573

Эх үүсвэр: УСХ, Нийгмийн зарим үзүүлэлийн мэдээ

31. **Хүүхдийн тэтгэлэг авдаг хүүхэд, авч чадахгүй байгаа хүүхэд:** 2025 оны байдлаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт (ШШГЕГ) бүртгэгдсэн тэтгэлэг авах хүүхдийн тоо 19.7 мянга байгаа бол тэтгэлэг авч чадахгүй байгаа хүүхдийн тоо 8.8 мянга байна. Өмнөх онтой харьцуулахад тэтгэлэг авахаар ШШГЕГ-т бүртгүүлсэн хүүхэд 9.5 хувь, тэтгэлэг авч чадахгүй хүүхэд 3.1 хувиар нэмэгдсэн байна.


ЗУРАГ 2218. ТЭТГЭЛЭГ АВАХААР ШШГЕГ-Т БҮРТГЭГДСЭН БОЛОН ТЭТГЭЛЭГ АВЧ ЧАДАХГҮЙ БАЙГАА ХҮҮХДИЙН ТОО



Эх үүсвэр: Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар

32. **Хорих ангид хоригдож байгаа хүүхэд:** 2025 оны байдлаар нийт 24 хүүхэд шүүхээр ял шийтгүүлж хорих ангид хоригдож байгаа бөгөөд өмнөх оноос 24-өөр буурчээ.


Зураг 2319. Хорих ангид хоригдож байгаа хүүхдийн тоо



Эх үүсвэр: Цагдаагийн ерөнхий газар

33. Ял хойшлуулсан, албадлагын чанартай арга хэмжээ авагдсан хүүхэд: 2024 онд нийт 38 хүүхдэд ял хойшлуулсан, албадлагын чанартай арга хэмжээ авсан бол 2025 онд 6 болж, 32-оор буурсан байна.

ЗУРАГ 24. ЯЛ ХОЙШЛУУЛСАН, АЛБАДЛАГЫН ЧАНАРТАЙ АРГА ХЭМЖЭЭ АВАГДСАН ХҮҮХЭД



Эх үүсвэр: Шүүхийн ерөнхий зөвлөл

34. Дотуур байрны хүүхэд: 2025/2026 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийн суралцагчдаас дотуур байранд 34.2 мянган хүүхэд амьдарч байгаа нь өмнөх оноос 1.3 мянга буюу 3.7 хувиар буурчээ. Үүнээс эмэгтэй суралцагчид 51.4 хувь, эрэгтэй суралцагчид 48.6 хувийг эзэлж байна.

ХҮСНЭГТ 5. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН СУРАЛЦАГЧДААС ДОТУУР БАЙРАНД АМЬДАРЧ БҮЙ ХҮҮХЭД, ХҮЙСЭЭР

Үзүүлэлт	2021/2022	2022/2023	2023/2024	2024/2025	2025/2026
Бүгд	32 576	35 077	36 029	35 486	34 177
Эмэгтэй	16 752	17 920	18 491	18 220	17 584
Эрэгтэй	15 824	17 157	17 538	17 266	16 593

Эх үүсвэр: Боловсролын яам

35. Цэцэрлэгийн хүүхэд: 2025/2026 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролд 258.8 мянган хүүхэд хамрагдсан нь өмнөх оноос 6.0 мянга буюу 2.3 хувиар буурчээ. Үүнээс эмэгтэй суралцагчид 48.8 хувь, эрэгтэй суралцагчид 51.2 хувийг эзэлж байна.

ХҮСНЭГТ 6. СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛД ХАМРАГДСАН ХҮҮХЭД, ХҮЙСЭЭР

Үзүүлэлт	2021/2022	2022/2023	2023/2024	2024/2025	2025/2026
Бүгд	190 991	266 024	274 236	264 818	258 849
Эмэгтэй	93 362	129 875	134 124	129 476	132 453
Эрэгтэй	97 629	136 149	140 112	135 342	126 396

Эх үүсвэр: Боловсролын яам

36. Сургууль завсардсан хүүхэд: 2025/2026 оны хичээлийн жилд ерөнхий боловсролын сургуулийг завсардсан хүүхэд 304 болж, өмнөх оноос 36 буюу 10.6 хувиар буурсан байна. Үүнээс 34.2 хувь нь эмэгтэй, 65.8 хувь нь эрэгтэй хүүхэд байна.


ХҮСНЭГТ 7. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИАС ЗАВСАРДСАН ХҮҮХЭД

Үзүүлэлт	2021	2022	2023	2024	2025
Бүгд	987	656	454	340	304
Эмэгтэй	380	235	283	128	104
Эрэгтэй	607	421	171	212	200

Эх үүсвэр: Боловсролын яам

37. **Бичиг үсэггүй хүүхэд:** ТХЗ-ийн 4.1.1-ийн шалгуур үзүүлэлтэд 2, 3 дугаар анги, бага анги, дунд анги төгсөгчдийн унших суурь чадвар эзэмшсэн хүүхдийн хувь гэсэн үзүүлэлт ордог. Энэхүү үзүүлэлтийг Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаагаар тооцдог бөгөөд ЕБС-ын 2 дугаар ангийн сурах бичгээс богино эх сонгон уншуулж, эхийн үгийг 90-ээс дээш хувь зөв уншсан, эхтэй холбоотой шууд хариулах 3, учир шалтгаан тодруулсан 2 асуултад зөв хариулсан хүүхдийг унших суурь чадвар эзэмшсэн гэж тодорхойлсон. 2023 оны судалгаагаар унших суурь чадвар эзэмшсэн 2, 3 дугаар ангийн хүүхдийн хувь 64.4 хувь, бага ангид суралцагчид 71.8 хувь, дунд ангид суралцагчид 84.8 хувь болж, өмнөх судалгаанаас 14.5 -20.0 нэгж хувиар тус тус өссөн байна.

ЗУРАГ 25. 7-14 НАСНЫ ХҮҮХДИЙН УНШИХ ЧАДВАР



Эх үүсвэр: ҮСХ, Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа

38. **Хорт зуршил:** ҮСХ-ноос 2023 онд зохион байгуулсан Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаагаар 15 нас хүрэхээсээ өмнө тамхи татаж үзсэн хүн амын судалгааг хийсэн. Судалгаагаар 15-49 насны хүн амын 10.6% нь 15 нас хүрэхээсээ өмнө тамхи татаж үзсэн гэж хариулсан. Үүнээс эрэгтэйчүүдийн 20% нь, эмэгтэйчүүдийн 1.6% нь 15 нас хүрэхээсээ өмнө тамхи татаж үзсэн гэж хариулсан байна. Харин 15 нас хүрэхээсээ өмнө 15-49 насны хүн амын 2.6% нь архи хэрэглэж үзсэн гэжээ. Үүнээс эрэгтэйчүүдийн 4.5%, эмэгтэйчүүдийн 0.9% нь 15 нас хүрэхээсээ өмнө архи хэрэглэж үзсэн гэж хариулжээ.
39. **Сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл, мансуурах донтой хүүхэд:** ЭМЯ-ны мэдээгээр сэтгэцэд нөлөөт эм, бодисын шалтгаант сэтгэцийн ба зан төрхийн эмгэгүүд оноштой 36 хүүхэд байгаа нь өмнөх оноос 26 (3.6 дахин)-аар нэмэгдсэн байна.


ХҮСНЭГТ 8. СЭТГЭЦЭД НӨЛӨӨТ ЭМ, БОДИСЫН ШАЛТГААНТ СЭТГЭЦИЙН БА ЗАН ТӨРХИЙН ЭМГЭГҮҮД

	2021			2022			2023			2024			2025		
	10 хүртэлх	10-14	15-19	10 хүртэлх	10-14	15-19	10 хүртэлх	10-14	15-19	10 хүртэлх	10-14	15-19	10 хүртэлх	10-14	15-19
Сэтгэгц нөлөөт эм, бодисын шалтгаант сэтгэцийн ба зан төрхийн эмгэгүүд /F10-F19/	1	2	6	0	0	2	0	0	3	0	6	4	0	9	27

Эх үүсвэр: Эрүүл мэндийн яам

40. **Эцэг эхийн хэн нэгэнтэйгээ амьдарч буй хүүхэд:** 2025 оны байдлаар нийт 54,942 хүүхэд, үүнээс эцэг эхийн хэн нэг нь нас барсны улмаас 28,063 хүүхэд, гэр бүл салсны улмаас 15,645 хүүхэд эцэг эхийн хэн нэгэнтэйгээ амьдарч байна.


ЗУРАГ 26. ЭЦЭГ, ЭХИЙН ХЭН НЭГЭНТЭЙ АМЬДАРЧ БАЙГАА ХҮҮХЭД, ШАЛТГААНААР, 2025 ОНД



Эх үүсвэр: ҮСХ, Нийгмийн зарим үзүүлэлтийн мэдээ

41. **Бүтэн өнчин:** 2025 оны байдлаар 2,802 бүтэн өнчин хүүхэд байгаагийн 51.5 хувь нь эрэгтэй, 48.5 хувь нь эмэгтэй хүүхэд байна. Бүтэн өнчин хүүхэд өмнөх оны мөн үеэс 226 (8.8%) хүүхдээр өссөн байна.

ЗУРАГ 27. БҮТЭН ӨНЧИН ХҮҮХЭД



Эх үүсвэр: ҮСХ, Нийгмийн зарим үзүүлэлтийн мэдээ

42. **Хилээр гарсан хүүхэд:** Улсын хилээр гарсан хүүхдийн тоо сүүлийн 5 жилийн хугацаанд тогтмол нэмэгдэж байна. 2025 онд 316.2 мянган хүүхэд хилээр гарсан нь өмнөх оноос 25.4 хувиар нэмэгджээ.

ХҮСНЭГТ 9. УЛСЫН ХИЛЭЭР ГАРСАН ХҮҮХЭД

Он	2022	2023	2024	2025
Улсын хилээр гарсан	42 929	141 030	252 143 ¹	316 212 ¹

¹ 2023 оны 12 дугаар сарын 28-ны А/182 дугаар тушаалаар батлагдсан Улсын хилээр нэвтэрсэн зорчигч тээврийн хэрэгслийн мэдээний шинэчилсэн маягтын дагуу 2024 оны 7 дугаар сараас эхлэн насны бүлгээр тоо мэдээг гаргаж эхэлсэн. Иймээс 2024 оны сүүлийн хагас жилийг 0-19 насны хүүхдийн тооны нийлбэрээр тооцсон болно.
Эх үүсвэр: Хил хамгаалах ерөнхий газар

43. **Гадаадад амьдарч буй хүүхэд:** Сүүлийн 5 жилийн хугацаанд гадаадад оршин суугаа хүүхдийн тоог авч үзвэл, 2021 онд 17.9 мянга, 2022 онд 17.6 мянга, 2023 онд 20.3 мянга, 2024 онд 29.3 мянга, 2025 онд 27.5 мянган хүүхэд байна.

ХҮСНЭГТ 10. ГАДААДАД АМЬДАРЧ БУЙ ХҮҮХЭД

Үзүүлэлт	2021	2022	2023	2024	2025
Бүгд	17 980	17 665	20 341	29 329	27 478

Эх үүсвэр: УСХ, Хүн ам, орон сууцны 2025 оны завсрын тооллогын дүн

44. **Үрчлэлт:** 2025 оны жилийн эцсийн байдлаар 1,046 хүүхэд үрчлэгдсэн бөгөөд өмнөх оноос 11.0 хувиар буурчээ. Нийт үрчлэгдсэн хүүхдийн 63.5 хувь нь 7 хүртэлх насны хүүхдүүд байгаа бол 36.5 хувь нь 7, түүнээс дээш насныхан байна.

ХҮСНЭГТ 11. ҮРЧЛЭГДСЭН ХҮҮХДИЙН ТОО, НАСНЫ БҮЛЭГ, ЖИЛЭЭР

Насны бүлэг	2021	2022	2023	2024	2025
Бүгд	1 261	1 478	1 421	1 175	1 046
3 хүртэл	572	555	537	445	438
3-6	295	386	331	285	226
7-9	112	160	152	131	112
10, түүнээс дээш	282	377	401	314	270

Эх үүсвэр: Улсын бүртгэлийн ерөнхий газар

45. **Гадаадад сургуульд сурдаг хүүхэд:** 2024/2025 оны хичээлийн жилд 5-18 насны гадаадад суралцагчид 2,744 болж, өмнөх оноос 1,085 буюу 65.4 хувиар өссөн байна. Үүнээс: 60.2 хувь нь эмэгтэй, 39.8 эрэгтэй суралцагчид байна.

ХҮСНЭГТ 12. ГАДААДАД СУРГУУЛЬД СУРДАГ 5-18 ХҮРТЭЛХ НАСНЫ ХҮҮХЭД

Үзүүлэлт	2021/2022	2022/2023	2023/2024	2024/2025
Бүгд	1 421	813	1 659	2 744
Эмэгтэй	772	429	1 049	1 653
Эрэгтэй	649	384	610	1 091

Эх үүсвэр: Боловсролын яам

46. **Хөдөлмөр эрхлэгч хүүхэд /эрхэлдэг ажил тус бүрээр/:** Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн 2021-2022 оны судалгааны үр дүнгээр Монгол Улсын хэмжээнд 5-17 насны хүүхдүүдийн 138.5 (16.3%) мянган хүүхэд, үүнээс 133.2 мянга (96.2%) нь өөрийн эцсийн хэрэглээний үйлдвэрлэлийн ажил эрхэлсэн, 11.6 мянга (8.4%) нь цалин хөлс, орлого олох зорилготой ажил эрхэлсэн, 0.2 мянга (0.2%) нь цалин хөлсгүй дадлагажих ажил эрхэлсэн байна.

47. **Хурдан морь уралдаанч хүүхэд:** Хурдны морины уралдаанч хүүхдийн тоо 2025 онд 16.1 мянга болж, өмнөх оноос 39 буюу 0.2 хувиар буурчээ.


ЗУРАГ 28. ХУРДАН МОРИНЫ УРАЛДААНЧ ХҮҮХЭД, УРАЛДААНЫ ТОО



Эх үүсвэр: Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газар

48. **Морь уралдаж байгаад амь насаа алдсан хүүхэд:** ЭМЯ-наас мориноос унаж нас барсан хүүхдийн мэдээллийг гаргадаг ба 2024 онд 14 байсан бол 2025 онд 7 болж, өмнөх оноос 7 (50.60) хүүхдээр буурсан байна.


ЗУРАГ 29. МОРИНООС УНАЖ НАС БАРСАН ХҮҮХДИЙН ТОО



Эх үүсвэр: Эрүүл мэндийн яам


49. **Үл хайхрах хүчирхийлэлд өртсөн хүүхэд:** Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын мэдээгээр 2025 онд хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан 16.7 мянган хүүхдийн 12.8 (76.8%) мянга нь ямар нэг хүчирхийлэлд өртжээ. Хүчирхийлэлд өртсөн хүүхдийн 8.3 (64.7%) мянга нь үл хайхрах хүчирхийлэлд өртсөн байна. (Мэдээллийг 2024 оноос эхлэн цуглуулж эхэлсэн)

ЗУРАГ 30. ХҮЧИРХИЙЛЭЛД ӨРТСӨН ХҮҮХЭД, ТӨРЛӨӨР



50. Бие махбодын хүчирхийлэлд өртсөн хүүхэд: Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааны 2023 оны үр дүнгээр сүүлийн 1 сарын хугацаанд 1-14 насны хүүхдийн 22.4 хувь нь ямар нэг бие махбодын хүчирхийлэлд өртсөн нь өмнөх судалгааны үр дүнгээс 5.6 нэгж хувиар буурчээ.

ЗУРАГ 31. ХҮҮХДИЙГ ХҮМҮҮЖҮҮЛЭХЭД ӨРХИЙН ГИШҮҮДИЙН ЗҮГЭЭС ХҮЧИРХИЙЛЛИЙН АРГА ХЭРЭГЛЭСЭН 1-14 НАСНЫ ХҮҮХЭД




Тайлбар: * 2-14 насны хүүхдийн хувь
Эх үүсвэр: ҮСХ, Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа

51. Сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн хүүхэд: Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааны 2023 оны үр дүнгээр сүүлийн 1 сарын хугацаанд 1-14 насны хүүхдийн 38.4 хувь нь сэтгэл санааны хүчирхийлэлд өртөж өмнөх судалгаанаас 2.0 нэгж хувиар буурсан байна.

52. Эдийн засгийн хүчирхийлэлд өртсөн хүүхэд: Гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгааны 2023 оны үр дүнгээр сүүлийн 3 жилийн хугацаанд 14-17 насны хүүхдийн 6.9 хувь эдийн засгийн хүчирхийлэлд өртсөн байна. Мөн 2017 онд зохион байгуулан явуулсан “Жендэрт суурилсан хүчирхийллийн судалгаа”-ны үр дүнгээр 15-19 насны эмэгтэйчүүдийн 4.1 хувь нь амьдралдаа, 2.8 хувь нь сүүлийн 12 сарын хугацаанд эдийн засгийн хүчирхийлэлд өртсөн байна.

53. Хөгжих хэвийн орчин алдагдсан хүүхэд: 2023 оны Гэмт хэрэгт хохирох эрсдэлийн судалгаанд хамрагдсан 14-17 насны хүүхдийн 58.8 хувь нь оршин сууж байгаа газар нь орчны бохирдол хог хаягдал ихтэй гэж үзсэн бол 38.6 хувь нь амьдрах орчны таатай нөхцөлийг хангадаггүй гэж хариулсан байна.

ЗУРАГ 32. АМЬДРАХ ОРЧНЫ НӨХЦӨЛ БАЙДАЛ, 14-17 НАС, ДҮНД ЭЗЛЭХ ХУВИАР, 2023 ОН




Эх үүсвэр: ҮСХ, Гэмт хэрэгт, хохирох эрсдлийн судалгаа

54. Гамшигт нэрвэгдсэн хүүхэд: Онцгой байдлын ерөнхий газрын мэдээгээр 2024 онд 77 хүүхэд гамшигт нэрвэгдсэн байна.

55. Асрамж халамжийн төвд амьдардаг хүүхэд: 2025 оны байдлаар 847 хүүхэд төвлөрсөн асрамж, халамжийн үйлчилгээнд хамрагдсан нь өмнөх оноос 48 (5.4%) хүүхдээр буурсан байна.


ЗУРАГ 33. ТӨВЛӨРСӨН АСРАМЖ, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ХҮҮХДИЙН ТОО



Эх үүсвэр: Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам

56. Шилжиж ирсэн хүүхэд: Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээгээр 2025 онд нийт 59,447 хүн дотоод шилжих хөдөлгөөн хийсэн бөгөөд 0-19 насны 25,419 хүүхэд дотоод шилжилт хөдөлгөөнд оролцсон байна. Өмнөх онтой харьцуулахад нийт шилжилт хөдөлгөөнд оролцсон хүний тоо 3,180 (5.1%)-аар буурсан бол 0-19 насны шилжилт хөдөлгөөнд оролцсон хүүхдийн тоо 2,145 (9.2)-оор буурсан байна.


ЗУРАГ 34. ХҮН АМЫН ДОТООД ШИЛЖИЖ ИРСЭН ХӨДӨЛГӨӨН



*Тайлбар: УБЕГ шилжиж явсан хүний бүртгэлийг 2018 оноос хойш хуульд шинэчлэлт орсон тул бүртгэхгүй байгаа. Эх үүсвэр: Улсын бүртгэлийн ерөнхий газар

57. Хүүхдийн мөнгө авдаг хүүхэд: 2025 оны байдлаар нийт 1353.7 мянган хүүхэд хүүхдийн мөнгө авсан нь өмнөх оноос 12.7 (0.9%) мянган хүүхдээр нэмэгдсэн байна.


ЗУРАГ 35. ХҮҮХДИЙН МӨНГӨН ТЭТГЭМЖИД ХАМРАГДАЛТ, МЯНГАН ХҮН



58. Тэжээгчээ алдсаны тэтгэмж авдаг хүүхэд: 2025 онд нийгмийн халамжаас тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхдийн тэтгэмж авч байгаа 17,237 хүүхдэд байгаа бол нийгмийн даатгалын сангаас тэжээгчээ алдсаны тэтгэвэрт 22,675 хүн хамрагдсан байна. Нийгмийн даатгалын сангаас олгож буй тэтгэвэрт зөвхөн асран халамжлагчаар илэрхийлдэг.

59. Хүнсний талонд хамрагддаг хүүхэд: 2025 онд 0-18 насны нийт 52305 хүүхэд хүнсний талонд хамрагдсан нь өмнөх оноос 8,692 (19.2%) хүүхдээр өссөн байна.


ЗУРАГ 36. ХҮНС ТЭЖЭЭЛЛИЙН ДЭМЖЛЭГ ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН 0-18 НАСНЫ ХҮҮХЭД



60. Сэтгэл зүйн үйлчилгээнд хамрагдсан хүүхэд: (Мэдээллийг 2024 оноос эхлэн цуглуулж эхэлсэн) Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын ерөнхий газрын мэдээгээр 2024 онд 25.6 мянга, 2025 онд 16.7 мянган хүүхэд хамгааллын үйлчилгээ авсан байна. Үүнээс 2024 онд 6.8 (26.4%) мянга, 2025 онд 3.2 мянга нь сэтгэл зүйн зөвөлгөө авах үйлчилгээнд хамрагдсан байна.

61. Ахуйн осолд өртсөн хүүхэд: Онцгой байдлын ерөнхий газрын мэдээллээр, 2025 онд нийт 38 хүүхэд ахуйн осолд өртсөн нь өмнөх оноос 28.3 хувиар буурсан. 2025 онд ахуйн осолд өртсөн хүүхдүүдүүдээс 5 хүүхэд нас барсан байна.

ЗУРАГ 37. АХУЙН ОСОЛД ӨРТСӨН ХҮҮХДИЙН ТОО



Эх үүсвэр: Онцгой байдлын ерөнхий газар

62. **Зам тээврийн осолд өртсөн хүүхэд:** 2025 оны байдлаар нийт 305 хүүхэд зам тээврийн ослын хохирогч болсон болсон бөгөөд үүнээс 251 хүүхэд гэмтэж, 54 хүүхэд нас барсан байна.


ХҮСНЭГТ 13. ЗАМ ТЭЭВРИЙН ОСЛЫН ХОХИРОГЧ БОЛСОН ХҮҮХЭД

Үзүүлэлт	2021	2022	2023	2024	2025
Зам тээврийн ослын хохирогч болсон хүүхэд	155	230	238	290	305
Гэмтсэн хүүхэд	104	176	187	239	251
Нас барсан хүүхэд	51	54	51	51	54

Эх үүсвэр: Цагдаагийн ерөнхий газар

63. **Нохойд хазуулсан хүүхэд:** ЭМЯ-ны мэдээллээр 2025 онд нийт 2.2 мянган хүүхэд нохойд хазуулсан байгаа нь өмнөх оноос 207 (10.4%) хүүхдээр нэмэгдсэн байна.


ЗУРАГ 38. НОХОЙД ХАЗУУЛСАН ХҮҮХДИЙН ТОО



Эх үүсвэр: Эрүүл мэндийн яам

64. **Голд живсэн хүүхэд:** Онцгой байдлын ерөнхий газрын мэдээллээр, 2025 онд нийт 28 хүүхэд усны осолд өртсөн нь өмнөх оноос 15.2 хувиар өссөн байна. 2025 онд усны осолд өртсөн 21 хүүхэд нас барсан байна.


ЗУРАГ 39. УСНЫ ОСОЛД ӨРТСӨН ХҮҮХДИЙН ТОО



Эх үүсвэр: Онцгой байдлын ерөнхий газар

65. Өндрөөс унасан хүүхэд: Онцгой байдлын ерөнхий газрын мэдээллээр, 2025 онд нийт 5 хүүхэд өндрөөс унах осолд өртсөн байна. Харин 2022 онд 1 хүүхэд амь насаа алдсан тохиолдол бүртгэгдэж байсан бөгөөд үүнээс хойш сүүлийн жилүүдэд амь нас хохирсон осол бүртгэгдээгүй байна.


ЗУРАГ 40. ӨНДРӨӨС УНАХ ОСОЛД ӨРТСӨН ХҮҮХДИЙН ТОО



Эх үүсвэр: Онцгой байдлын ерөнхий газар

66. Жорлонд унасан хүүхэд: Онцгой байдлын ерөнхий газрын мэдээллээр, 2025 онд нийт 3 хүүхэд жорлонгийн нүхэнд унасан осолд өртсөн байна. Харин 2023 онд 2 хүүхэд амь насаа алдсан тохиолдол бүртгэгдэж байсан бөгөөд 2025 онд мөн 2 хүүхэд амь нас хохирсон тохиолдол бүртгэгдсэн байна.


ЗУРАГ 41. ЖОРЛОНД УНАХ ОСОЛД ӨРТСӨН ХҮҮХДИЙН ТОО



Эх үүсвэр: Онцгой байдлын ерөнхий газар

67. Харшилтай хүүхэд: ЭМЯ-ны мэдээллээр 2025 онд арьсны харшилтай хүүхдийн 14.7 мянган тохиолдол бүртгэгдэж, өмнөх оноос 1230 (9.1%) тохиолдлоор нэмэгдсэн байна.


ЗУРАГ 42. ХАРШИЛТАЙ ХҮҮХДИЙН ТОО



Эх үүсвэр: Эрүүл мэндийн яам

68. Тураалтай хүүхэд: Нийгмийн үзүүлэлтийн 2023 оны түүвэр судалгааны үр дүнгээр 5 хүртэлх насны хүүхдийн 1.9 хувь нь насандаа тохирсон жингээс дунд болон хүнд хэлбэрийн тураалтай байгаа нь өмнөх судалгаанаас 0.1 нэгж хувиар өссөн байна. Хүнд хэлбэрийн тураалтай хүүхдийн хувь 2023 онд 0.8 болж, өмнөх судалгаанаас 0.3 нэгж хувиар нэмэгджээ.


ЗУРАГ 43. 5 ХҮРТЭЛХ НАСНЫ ТУРААЛТАЙ ХҮҮХЭД



Эх үүсвэр: УСХ, Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа

69. Хамгаалах байрны үйлчилгээ авсан хүүхэд: 2025 оны байдлаар 2115 хүүхэд тус үйлчилгээнд хамрагдсан нь өмнөх оноос 174 (7.6%) хүүхдээр буурсан байна.

ЗУРАГ 44. ХАМГААЛАХ БАЙРНЫ ҮЙЛЧИЛГЭЭ АВСАН ХҮҮХЭД



Эх үүсвэр: Хүүхэд, гэр бүл хөгжил, хамгааллын ерөнхий газар

70. **Нөхөн сэргээх үйлчилгээнд хамрагдсан хүүхэд:** Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газрын мэдээгээр хамгаалах, нөхөн сэргээх үйлчилгээнд 2024 онд 17.2 мянга, 2025 онд 12.6 мянган хүүхэд хамрагдсан байна.
71. **Урьдчилан сэргийлэх үйлчилгээнд хамрагдсан хүүхэд:** Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газрын мэдээгээр 2025 онд хүүхэд хамгааллын урьдчилсан сэргийлэх түвшний үйлчилгээнд 53.8 мянган хүүхэд хамрагдсаны 6.8 мянга нь нийслэлээс, 47.0 мянга нь орон нутгаас хамрагдсан байна.
72. **Спортын секц дугуйланд хамрагддаг хүүхэд:** Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газрын мэдээгээр биеийн тамир, спортын үйлчилгээнд 2024 онд 143.3 мянган хүүхэд хамрагджээ. 2025 онд 85.4 мянган хүүхэд хамрагдсан нь өмнөх оноос 57.9 (40.4%) мянгаар буурсан байна.
73. **Урлагийн төрлөөр дугуйланд хамрагддаг хүүхэд:** Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газрын мэдээгээр соёл урлагийн үйлчилгээнд 2024 онд 52.4 мянга, 2025 онд 72.0 мянган хүүхэд хамрагдсан байна.
74. **Хүүхдийн сайн сайхан байдлыг хангах хөрөнгө оруулалтын дүн /улс, нийслэл, аймаг, дүүрэг, хороо, сум, тосгон, баг/:** 2024/2025 оны хичээлийн жилд бүх шатны боловсролын байгууллагад зарцуулсан зардал 7.8 тэрбум төгрөг болж, өмнөх оноос 2.2 тэрбум төгрөг буюу 39.7 хувиар өссөн байна.


ХҮСНЭГТ 14. БҮХ ШАТНЫ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГАД ЗАРЦУУЛСАН ЗАРДАЛ, МЯНГАН ТӨГРӨГ

	2021	2022	2023	2024	2025
Бүгд	4 008 154.0	4 281 101.7	5 594 389.4	7 816 073.6	10 541 948.2
СӨБ	536 357.5	589 532.3	816 626.0	1 110 799.6	1 189 069.6
ЕБС	1 241 772.3	1 344 175.5	1 729 199.8	2 426 817.3	2 903 600.7
ТБМБ	12 993.5	13 677.4	17 762.9	24 929.0	25 237.1
Их, дээд сургууль	2 217 030.7	2 333 716.5	3 030 800.6	4 253 527.7	6 424 040.8

Эх үүсвэр: Боловсролын яам

75. **Боловсролын үйлчилгээнд хамрагддаг нийт хүүхэд:** 2025/2026 оны хичээлийн жилд бүх шатны боловсролын байгууллагад нийт 1284.2 мянган хүүхэд суралцаж байгаа нь өмнөх оноос 27.8 мянга буюу 2.2 хувиар өссөн байна.


ЗУРАГ 45. БҮХ ШАТНЫ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГАД СУРАЛЦАГЧИД, МЯНГАН ХҮНЭЭР



Эх үүсвэр: Боловсролын яам

76. **Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд хамрагдсан нийт хүүхэд:** 2025 онд эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд давхардсан тоогоор 3787.7 мянган хүүхэд хамрагдсан байна. Энэ нь өмнөх оноос 24.4 мянган хүүхэд (0.6%)-ээр нэмэгджээ.

ЗУРАГ 46. ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ХҮҮХДИЙН ТОО /ДАВХАРДСАН ТООГООР/




Эх үүсвэр: Эрүүл мэндийн яам

77. **Хууль эрх зүйн үйлчилгээнд хамрагдсан нийт хүүхэд:** Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газрын мэдээгээр 2025 онд давхардсан тоогоор 1.8 мянган хүүхэд хууль эрх зүйн үйлчилгээ авсан байна.

78. **Дотуур байранд амь насаа алдсан хүүхэд:** ЦЕГ-ын гэмт хэргийн мэдээгээр 2024 онд гэмт хэргийн улмаас дотуур байранд амь насаа алдсан 2 хүүхэд бүртгэгдсэн байна.

79. **Цахим дарамт, хүчирхийлэл, залиланд өртсөн хүүхэд:** 2025 онд нийт 18 хүртэлх насны 74 хүүхэд дээрэмдэх гэмт хэргийн, 113 хүүхэд залилах гэмт хэргийн хохирогч болсон байна. Өмнөх онтой харьцуулахад залилах гэмт хэргийн хохирогч 31 (21.5%)-ээр буурч, дээрэмдэх гэмт хэргийн хохирогч 2 (2.8%)-оор өссөн байна.

ЗУРАГ 47. ГЭМТ ХЭРЭГТ ӨРТСӨН ХҮҮХДИЙН ТОО, ГЭМТ ХЭРГИЙН ТӨРЛӨӨР



Эх үүсвэр. Цагдаагийн ерөнхий газар

80. **Цахим дарамт үйлдсэн хүүхэд:** Гэмт хэрэгт хохирох эрсдэлийн 2023 оны судалгаанд хамрагдсан 14-19 насны хүүхдийн 22.5 хувь нь сүүлийн 3 жилд цахим орчны дарамтад өртсөн байна.

81. **Өмгөөллийн үйлчилгээ авсан хүүхэд:** Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газрын мэдээгээр 2024 онд давхардсан тоогоор 287 өмгөөллийн үйлчилгээ авсан байна.
82. **Хөгжлийн үйлчилгээнд хамрагдсан хүүхэд:** 2025 онд хүүхэд, хөгжил, хамгааллын үйлчилгээнд давхардсан дүнгээр 297.7 мянган хүүхэд хамрагдсаны 46.5 хувь нь эрэгтэй, 53.5 хувь нь эмэгтэй байна.


ХҮСНЭГТ 15. ХҮҮХЭД, ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДАЛТ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨРЛӨӨР, 2025 ОН

Үйлчилгээний төрөл	Нийт	Хүйсээр	
		Эрэгтэй	Эмэгтэй
Бүгд	297 743	138 490	159 253
Соёл урлаг	71 896	29 725	42 171
Биеийн тамир спорт	85 358	42 715	42 643
Оюун ухаан	53 276	23 996	29 280
Амьдрах ухаан	23 832	13 802	10 030
Хувь хүний хөгжил	40 164	19 450	20 714
Сошиал, медиа	11 535	3 429	8 106
Техник сэтгэлгээ, зохион бүтээх	11 682	5 373	6 309

Эх үүсвэр: Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газар

83. **Зусланд хамрагдсан хүүхэд:** Хүүхэд, гэр бүлийн хөгжил хамгааллын ерөнхий газрын мэдээгээр 2025 онд 54.2 мянган хүүхэд зусланд хамрагдсан байна.
84. **Шилжиж ирсэн, явсан хүүхэд /ЕБС/:** 2025/2026 оны хичээлийн жилд 133.6 мянган хүүхэд сургууль хооронд шилжилт хөдөлгөөн хийсэн нь өмнөх оноос 4.2 мянга буюу 3.1 хувиар буурсан байна.

ЗУРАГ 48. ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ ХООРОНДЫН ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН



Эх үүсвэр: Боловсролын яам

85. **Политехникийн коллежийн хүүхэд /15-17 нас/:** 2025/2026 оны хичээлийн жилд техникийн болон мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагад суралцаж байгаа 15-17 насны хүүхэд 24,087 байгаа нь өмнөх оны мөн үеэс 809 буюу 3.5 хувиар өссөн байна. Үүнээс эрэгтэй суралцагчид 70.0 хувь, эмэгтэй суралцагчид 30.0 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны мөн үеэс эрэгтэй суралцагчдын тоо 0.3 нэгж хувиар өсөж, эмэгтэй суралцагчид 0.3 нэгж хувиар буурсан үзүүлэлттэй байна.

**ХҮСНЭГТ 16. ТЕХНИКИЙН БОЛОН МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ СУРГАЛТЫН БАЙГУУЛЛАГАД
СУРАЛЦАГЧИД, ХҮЙСЭЭР**

Үзүүлэлт	2021/2022	2022/2023	2023/2024	2024/2025	2025/2026
Бүгд	19 778	19 984	21 059	23 278	24 087
Эмэгтэй	6 358	6 297	6 622	7 063	7 220
Эрэгтэй	13 420	13 687	14 437	16 215	16 867

Эх үүсвэр: Боловсролын яам